



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 04 сарын 16-ны
өдрийн 3882 дугаарт бүтээгдсэн

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын цэвэр, бохир
усны үйлчилгээний тариф, батлах тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний хүн амын тарифыг нэгдүгээр, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тарифыг хоёрдугаар, зөөврийн ус хангамж, бохир ус зөөврөөр татан зайлуулах үйлчилгээний тарифыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид "ТЗЭ" гэх/ аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.

3. Тариф шинэчлэн батлагдсантай холбогдуулан борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ (БОШ)-г хянуулж батлуулахыг ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, үр дүнтэй ажиллахыг ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2016 оны 94, 2017 оны 05, 2017 оны 73 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, ТЗЭ-дэд зөвлөмж хүргүүлэн, үр дүнг тооцож ажиллахыг Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба /Б.Доржбат/, Үнэ тарифын алба /Ж.Гэрэлчулуун/-нд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Э.ПҮРЭВЖАВ


ГИШҮҮН

Б.ЖИГЖИД

Ч.БАТТОГТОХ

С.ЧУЛУУНХУЯГ

Р.НЯМЖАВ



Хот, суурины ус хангамж, ариутгах
татуургын ашиглалт, үйлчилгээг
захицуулах зөвлөлийн 2018 оны 03-р
сарын 30-ны өдрийн 32 тоот тогтоолын
нэгдүгээр хавсралт

Улаанбаатар хотын хүн амд мөрдөх
цэвэр, бохир усны үйлчилгээний тариф
(НӨАТ-гүй)

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф
1.	Цэвэр ус	Тоолууртай	төг/л 0.62
		Тоолуургүй	төг/л 0.90
2.	Бохир ус	Тоолууртай	төг/л 0.47
		Тоолуургүй	төг/л 0.65



--- о О о ---

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны 05-р сарын 30-ны өдрийн 32 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

**Улаанбаатар хотын үйлдвэр, аж ахуйн нэгж,
байгууллагад мөрдөх цэвэр, бохир усны
үйлчилгээний тариф
(НӨАТ-гүй)**

№	Үйлчилгээний төрөл		Хэмжих нэгж	Тариф
1.	Цэвэр ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	1.20
		Төсөвт байгууллага	төг/л	1.20
		Спирт, архи, пиво, ундаа, усны үйлдвэр, машин угаалга	төг/л	1.60
		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	1.20
2.	Бохир ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	1.00
		Төсөвт байгууллага	төг/л	1.00
		Спирт, архи, пиво, ундаа, усны үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр	төг/л	1.35
		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, машин угаалга	төг/л	1.80
3.	Урьдчилан цэвэрлэх байгууламжийн бохир ус цэвэрлэх үйлчилгээ		төг/л	2.10



--- о о о ---

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны 03-р сарын 30-ны өдрийн 32 тоот тогтоолын гуравдугаар хэсэралт

Улаанбаатар хотын зөөврийн ус хангамж,
бохир ус зөөврөөр татан зайлуулах
үйлчилгээний тариф
(НӨАТ-гүй)

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф	
1.	Цэвэр ус	Төвлөрсөн шугамын ус түгээх байр	төг/л	0.909
		Зөөврийн ус түгээх байр	төг/л	0.909
		Зуслангийн болон алслагдсан зориулалтын цэгт	төг/л	2.727
		Ачилтын ус түгээх байр	төг/л	1.636
2.	Бохир ус	Цооногтой айл өрх	төг/л	0.37
		Цооногтой үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	0.70

*Тайлбар: Ачилтын ус түгээх байр /УТБ/, Цооногтой айл өрх, Цооногтой үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага зэрэг ангиллуудад тээврийн зардал ороогүй болно.



--- о О о ---